

ТА ИНТЕРНЕТ БАНК БОЛОН 319708, 319709
УТСААР ХОЛБОГДОН ВАЛЮТЫН ХАНШ
ТОХИРОХ БОЛОМЖТОЙ.

2022.02.22

Онцлох мэдээ

- Даваа гарагт ОХУ-ын ерөнхийлөгч Владимир Путин Украины зүүн хэсэгт салан тусгаарласан 2 бүс нутгийг бие даасан гэж хүлээн зөвшөөрсний дараа цэрэг оруулахыг тушааснаар томоохон дайн дэгдэнэ гэсэн Барууны айдсыг улам бүр нэмэгдүүллээ.
- ОХУ-ын эдийн засаг энэ оны 1-р улиралд 5.5%-иар тэлэх төлөвтэй байгаа бөгөөд жилийн байдлаар инфляцийн түвшин 8.5% орчимд эргэлдэж буй нь хязгаарлаж байна хэмээн төв банкнаас мэдээлэв.

Валютын зах зээл

ОХУ-аас Украины зүүн хэсэгт салан тусгаарласан газарт цэрэг оруулахыг тушаасны дараа тус бүс нутгийн орчим дайны ирмэгт тулаад байгаа тул евро болон эрсдэлтэй валютууд суларч, иен 3 долоо хоногийн дээд түвшинд ойртов. Азийн эхэн үеийн арилжаагаар иен 0.2% чангарч 114.50 хүрсэн бол евро 0.1% унаж нэг долоо хоногийн доод цэг 1.1297 хүрлээ. Бас нэгэн эрсдэл багатай валют болох Швейцар франк шөнийн дотор 1 сарын дээд түвшинд хүрч өссөн байна. Рублийн ханш ам.долларын эсрэг Даваа гарагт 3 гаруй хувь унаж, өнөөдөр ч гэсэн үргэлжлүүлэн 0.3% доошилж 80.393 (15 сарын доод цэг)-т хүрлээ. Австрали доллар 0.1% суларч 0.7182-тай тэнцэв. Өчигдөр бараг 4 долоо хоногийн дээд цэгт ойртоод байсан юанийн ханш өнөөдөр буцаад уналаа. Өчигдөр 6.324 орчимд хэлбэлзэж байсан оффшор юань өнөөдөр 6.342-д арилжаалагдаж байна.

Алтны зах зээл

Мягмар гарагт алтны ханш 9 сарын дээд цэгтээ хүрээд байна. ОХУ цэргүүдээ Украины зүүн талын салан тусгаарласан нутаг дэвсгэрт орох тушаал өгснөөр эрсдэл багатай металлын эрэлт нэмэгдлээ. Өглөөний байдлаар 1 унц алтны ханш 0.2% өсөлттэй 1,909.54 ам.доллар боллоо. Үүний өмнө 6 сарын 1-нээс хойших дээд цэг 1,913.89 ам.доллар хүрээд байсан юм. АНУ-ын алтны фьючерс GCv1 0.7% өсөлттэй 1,913.60 ам.доллар болоод байна.

Зэсийн зах зээл

Никель болон хөнгөн цагааны ханшнууд хэдэн жилийн дээд түвшинд хүрсэн бөгөөд Зүүн Европ дахь хурцадмал байдал даамжирч ОХУ-ын нийлүүлэлт тасалдана гэсэн айдас голчлон нөлөөлжээ. Зэсийн хувьд эсрэгээр буураад байна. Лондонгийн Металлын Биржийн зэсийн фьючерс 0.1% доошилж 9,890 ам.долларт арилжаалагдах зуур Шанхайн Фьючерсийн Бирж дээрх зэсийн фьючерс 0.5% унаж 71,090 юаниар арилжаалагдаж байна. Олон Улсын Зэсийн Судалгааны Группийн хамгийн сүүлийн сарын тайлан мэдээгээр дэлхийн зах зээл 10-р сард 34,000 тонн баяжуулсан зэсийн алдагдалтай байсан 11-р сард 79,000 тонн болжээ.

Валют	Ханш	24ц өөрч.
EUR/USD	1.1303	-0.07%
USD/CNY	6.339	-0.10%
USD/RUB	79.7535	0.00%
USD/JPY	114.65	-0.08%
USD/KRW	1195.45	0.29%
AUD/USD	0.7195	0.07%
GBP/USD	1.3589	0.00%

Индекс	Нэгж	24ц өөрч.
Dow Jones	34079.2	-0.68%
S&P 500	4348.9	-0.72%
NASDAQ	13548.1	-1.23%
FTSE 100	7484.3	-0.39%
Nikkei 225	26327.9	-2.17%
DAX	14731.1	-2.07%
Hang Seng	23513.9	-2.71%

Метал	Ханш (USD)	24ц өөрч.
Алт	1908.87	0.14%
Мөнгө	24.14	1.00%
Нүүрс (Чин хуанг дао)	163.27	#VALUE!
Зэс (LME)	9898	-0.58%
Төмрийн хүдэр	708.50	3.43%
Газрын тос (NYME)	93.75	2.94%

LIBOR	Хүү	24ц өөрч.
US 1M LIBOR	0.17%	5.57%
US 3M LIBOR	0.48%	-0.30%
US 6M LIBOR	0.78%	1.00%
US 12M LIBOR	1.29%	-0.23%

Бонд	Хүү	24ц өөрч.
US Treasury 10Y	1.86%	-3.76%
UK Treasury 10Y	1.41%	2.18%
GE Treasury 10Y	0.21%	7.29%
JP Treasury 10Y	0.20%	-7.51%

Бонд (Монгол)	Хүү	Дуусах огноо	Өгөөж	24ц өөрч.
Чингис	5.13%	12/5/2022	3.03%	0.12%
Гэрэгэ	5.63%	5/1/2023	3.34%	0.10%
МУХБ 2023	7.25%	10/23/2023	4.32%	-0.10%
Хуралдай	8.75%	3/9/2024	3.97%	0.06%
ММС	9.25%	4/15/2024	23.77%	0.10%
МИК 2024	8.85%	8/2/2024	11.35%	0.00%
Номад	5.13%	4/7/2026	4.72%	0.03%
Монгол 27	3.50%	7/7/2027	4.98%	-0.01%
Монгол 31	4.45%	7/7/2031	5.41%	-0.05%
Самурай JPY	1.52%	12/25/2023	0.04%	0.01%

Хувьцаа	Ханш	24ц өөрч.
Turquoise Hill Resources	20.43	-0.49%
Mongolian Mining Corp	2.12	-1.40%
Erdene Resource Dev	0.44	-2.25%
Centerra Gold	11.39	-1.04%

Макро эдийн засаг (Монгол)	Огноо	Дүн
Инфляцийн түвшин	2022 (I)	14.6%
Бодлогын хүү	2022 (I)	6.5%
Банк хоорондын зах зээлийн хүү	2021 (XII)	6.08%
Хадгаламжийн дундаж хүү (төг)	2022 (I)	7.78%
Хадгаламжийн дундаж хүү (валют)	2022 (I)	2.26%
Зээлийн дундаж хүү (төг)	2022 (I)	15.5%
Зээлийн дундаж хүү (валют)	2022 (I)	9.21%

Ханшийн таамаглал					
Валют	Q1 22	Q2 22	Q3 22	Q4 22	2023
EUR/USD	1.12	1.13	1.15	1.16	1.19
GBP/USD	1.35	1.36	1.37	1.38	1.40
USD/CNH	6.38	6.35	6.40	6.41	6.28
USD/JPY	115	115	116	116	115
USD/RUB	76.0	75.0	75.0	73.0	75.0

Түүхий эд					
Алт	1800	1750	1707	1690	1650
Зэс	9620	9350	9400	9500	9550
Нүүрс	131.5	105.0	92.5	84.0	71.5

Эдийн засгийн голлох тоо мэдээ эх сурвалж: Блүүмбэрг

Өмнөх өдрийн үр дүн	Үр дүн	Таам.	Өмнөх
UK Flash Manufacturing PMI	57.3	-	57.3
FR Markit Mfg Flash PMI	57.6	-	55.5
GE Markit Mfg Flash PMI	58.5	-	59.8
JP Jibun Bank Mfg Flash PMI	52.9	-	55.4

Өнөөдөр хүлээгдэж буй мэдээ	Цаг	Таам.	Өмнөх
GE Ifo Curr Conditions New	17:00	96.6	96.1
GE Ifo Business Climate New	17:00	96.5	95.7
US Markit Svcs PMI Flash	22:45	-	51.1
US Markit Mfg PMI Flash	22:45	53.0	51.2
US Consumer Confidence	23:00	109.8	113.8

Маргааш хүлээгдэж буй мэдээ	Цаг	Таам.	Өмнөх
EU HICP Final YY	18:00	5.1%	5.1%
EU HICP Final MM	18:00	0.3%	0.4%
FR Business Climate Mfg	15:45	112.0	112.0

Газрын тосны зах зээл

ОХУ-аас Украины зүүн бүсийн 2 хэсэг нутагт цэргээ оруулж тусгаар бүс нутаг гэж мэдэгдсэнээр газрын тосны үнэ 2 гаруй ам.доллараар нэмэгдэж сүүлийн 7 жилийн хамгийн өндөр түвшинд хүрлээ. АНУ, Европын Холбоо тус үйлдлийг буруутгасан ч олон улсын хориг тавих нөхцөл байдал хараахан үүсээгүй байна гэж мэдэгдлээ. Brent газрын тосны үнэ 2.2 хувь өсөж 97.49 ам.долларт арилжаалагдаж байна.

Бондын зах зээл

Украины асуудал улам муудаж АНУ-ын засгийн бондын ханш өссөнөөр гол өгөөжүүдийг 1.9% доош оруулж энэ жил хүлээгээд байсан зарим алдагдлуудыг үгүй хийлээ. 10 жилийн өрийн бичгийн өгөөж 8 хүртэлх нэгжээр буурч 1.84% болж 2 сарын 4-нөөс хойших доод түвшинд хүрээд байна. Шалтгаан нь ОХУ-ын ерөнхийлөгч Владимир Путин Украины зүүн хэсгийн салан тусгаарласан улсуудыг хүлээн зөвшөөрч энхийг сахиулах цэргийн хүч оруулах магадлалаа нэмэгдүүлсэн нь юм.

Хөрөнгийн зах зээл

ОХУ-аас Украины нутагт цэрэг оруулснаар олон улсын геополитикийн эрсдэл нэмэгдэж хөрөнгийн зах зээл хүчтэй уналаа. Тус мэдээний дараа хөрөнгө оруулагчид эрсдэл багатай хөрөнгө оруулалтууд буюу засгийн газрын бонд, алтны позиц авч эхэллээ. Өнөөдөр өглөө Токёогийн арилжааны цагаар Nasdaq фьючерс 2.1 хувь, S&P500 1.5 хувь уналаа.

Мэдэгдэл

Энэхүү мэдээлэл нь ХХБ-ны нэрийн өмнөөс тус банкны харилцагчдад мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгддэг бөгөөд аливаа нэг гадаад валют, санхүүгийн хэрэгсэл худалдах, худалдан авах болон хөрөнгө оруулалтийг санал болгоогүй болно. Мөн энэхүү мэдээлэл нь аль нэгэн харилцагчийн хөрөнгө оруулалтанд, санхүүгийн байдал болон тусгайлсан эрэлт, хэрэгцээнд тулгуурлаагүй бөгөөд ХХБ нь энэхүү мэдээллийн үнэн зөв болон бодит байдалд ямарваа нэгэн баталгаа гаргахгүй ба мэдээллийг ашигласнаас үүдэн бий болох аливаа алдагдал, сөрөг үр дагаварт харуцлага хүлээхгүй болохыг мэдэгдэж байна. Энэхүү мэдээлэл нь зохиогчын эрх бүхий мэдээллүүдийг агуулж буй тул зөвшөөрөлгүйгээр хуулбарлах, хэвлэх, гуравдагч этгээдэд түгээхийг хатуу хориглоно. Хэрэв энэхүү мэдээллийг цаашид хүлээн авахаа зогсоохыг хүсвэл гарчиг хэсэгт "UNSUBSCRIBE" гэж бичин уг и-мэйлд харуу илгээнэ үү.